



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/МД.

Мандалговь

Эзэмшил газрын хэмжээг өөрчлөх, зарим хэсгийг нийтийн эзэмшилд шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, 39 дугаар зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Худалдааны гудамж-2-207 тоот) хаягт байршилтай иргэн Бааст овогтой Эрдэнэчимэг (УС:63101509)-ийн үйлчилгээний зориулалттай 500 м.кв (0,05га) эзэмшил газраас 191 м² (0,01 га) газарт 6-н айлын 3 давхар нийтийн орон сууц барьсан тул газрыг нийтийн эзэмшилд шилжүүлж, үлдсэн 352 м² (0,03га) газрыг иргэн Бааст овогтой Эрдэнэчимэгт үйлчилгээний зориулалтаар 21 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж Аймгийн Засаг даргын 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/364 тоот захирамжийн Б.Эрдэнэчимэг-т холбогдох хэсэг, мөн газар эзэмших 0391610 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210363